



# Инженер техникийн хэсгийн 1 дүгээр сарын үйл ажиллагааны тайлан

2023.01.31



# 1. Захиалагчийн хяналт:

Нийтийн зориулалттай орон сууцны барилгын 20 цахилгаан шатны шинэчлэлийн ажил 2022-2023 оны дамжин хэрэгжиж байна.

Үүнээс – Фүшили элеватор ХХК 4 лифт

Төвхөн трейд ХХК 5 лифт

Оакс экспресс монголиа ХХК 10 лифт

1 лифтний тендер шалгаруулалт зохион байгуулагдаж байна.

2023 онд шинэчлэгдэх 4 цахилгаан шатны жагсаалтыг НЗДТГ-т 2023.01.19-ний өдөр хүргүүлсэн.



## 2. Засвар, техник үйлчилгээ:

Гэрээт 53 ААНБ, СӨХ-дын 157 лифтэнд засвар, техник үйлчилгээ хийхээс 50 ААНБ, СӨХ-дын 140 лифт, мөн гүүрэн гарцны 8 лифт, нийт 148 лифтэнд засвар, техник үйлчилгээг хийлгэж, механикуудын ажлын гүйцэтгэлд хяналт тавьж бүртгэл хөтөлж ажилласан.

Тус хугацаанд “Эрхи-ийн хөршүүд” СӨХ 4 лифт, “Өргөө 144” СӨХ 3 лифт, “Найдвар 29, 30” СӨХ-ны 2 лифт, нийт 9 лифт гэрээ цуцласан.

Гэрээт ААНБ, СӨХ-доос нийт 30 дуудлага ирснийг цаг хугацаанд нь засварлан лифтүүдийг хэвийн ажиллагаанд оруулсан. Мөн тайлант хугацаанд “Кремль” СӨХ-ны 1 лифт, “Арт” СӨХ-ны 1 лифт, “Нарлаг-60” СӨХ-ны 1 лифт, нийт 3 лифтэнд томоохон хэмжээний засварын ажил хийсэн.





### 3. Гүүрэн гарц


Нийслэлийн Засаг даргын 2022 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн А/1320 тоот эрх шилжүүлэх тухай захирамж, Улаанбаатар хотын ерөнхий менежерийн 2022 оны 11 дүгээр сар 09-ний өдрийн Гүүрийн байгууламж, нүхэн гарцын байгууламжийн ашиглалт, үйлчилгээний ажил гүйцэтгүүлэх тухай А/227 тоот тушаалын хүрээнд Нийслэлийн хэмжээнд ашиглагдаж буй 4 гүүрэн гарцын 8 цахилгаан шатны хонгилд цахилгаан хүйтний улиралд ажиллуулах бэлтгэл ажлыг хангаж, лифтнүүдийн өдөр тутмын хэвийн ажиллагааг хариуцан ажиллаж байна.

ХУД-ын 3 дугаар хорооны 19-ийн гүүрэн гарцын урд талын лифтний үндсэн тэжээлийн утас гэмснийг 2023 оны 01 дүгээр сарын 05-ны өдөр УБЗЗАГ засварлан хэвийн ажиллагаанд оруулсан.

ХУД-ын 1 дүгээр хорооны 120-н мянгатын гүүрэн гарцын зүүн лифтний үндсэн тэжээлийн утас хайлж, баруун лифтний тоормозны плат шатсан байсныг 2023 оны 01 дүгээр сарын 12-ны өдөр засварлан хэвийн ажиллагаанд оруулсан.

Гадна орчны температур нэмэгдэж хүйтний эрч чангарсантай холбогдуулан 4 гүүрэн гарцын 8 цахилгаан шатыг **2023.01.20-2023.02.06**-ны өдөр хүртэл **түр хугацаанд зогсоогоод** байна. Мөн гүүрэн гарцуудын лифтний цэвэрлэгээ арчилгааны материалыг 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдөр тараан өгч, бүх лифтний санамжийг шинэчлэн байршуулсан.







## 4. Техникийн магадлал

Тайлант хугацаанд “Мастер проперти менежмент” ХХК 3 лифт, “Орон сууц 103” СӨХ 1 лифт, “Нарлаг 60” СӨХ-ны 4 лифт, “Сууц” СӨХ-ны 6 лифт, “Төгөл” СӨХ 2 лифт, “Бэрс 2” СӨХ-ны 5 лифт, “Эмон 48” СӨХ 1 лифт, “Монта виста” СӨХ 1 лифт, нийт 23 лифтэнд техникийн ээлжит магадлалыг хийж гүйцэтгээд байна.

Баянгол дүүргийн 5 дугаар хорооны **2 дугаар байрны 1, 2** дугаар орцны 2 лифт, Чингэлтэй дүүргийн 6 дугаар хорооны **72 дугаар байрны 2** дугаар орцны 1 лифт, **28 дугаар байрны 2** дугаар орцны 1 лифтэнд тус тус шаардлагатай сэлбэг хэрэгслийн техникийн тодорхойлолтыг боловсруулан тухайн дүүргийн ЗДТГ-т хүргүүлсэн.



## 5. Лифтчин бэлтгэх сургалт

### Шинэ сургалт



2023 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс “ГОЛДЕН РИЧ ОДЦ” ХХК-тай хамран лифтчин бэлтгэх сургалтыг зохион байгуулах гэрээг шинээр байгуулсан. Гэрээний хүрээнд лифтчин бэлтгэх сургалт зохион байгуулахаар 3 хүн бүртгээд байна.

Лифтчин бэлтгэх сургалтыг 3 дугаар сард зохион байгуулах төлөвлөгөөтэй байна.

# 6.Бусад ажил

## Албан бичиг

Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын нэгдсэн систем <https://erp.ulaanbaatar.mn/> нэгдсэн сайтаар ИТХ-т нийт **20** алын бичиг ирсэн байна.

Хяналтын инженер Ц.Уранбилэг **14**, Хяналтын инженер Б.Байгаль **4**, механик инженер Я.Батбаатар **2** албан бичгийн тус тус шийдвэрлэсэн байна.

## Сургалт

**Цахилгаан шат түүнд тавигдах ерөнхий шаардлагыг** мөрдүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих, аж ахуйн нэгж байгууллагуудад сурталчлан таниулах ажлын хүрээнд Хотын стандарт, хяналтын газраас зохион байгуулсан “Хотын стандарт хэлэлцүүлэг”-т хяналтын инженер Ц.Уранбилэг, Б.Байгаль нар 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдөр хамрагдсан.




## Бүх нийтийн цэвэрлэгээ

Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2023 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн “Нийслэлийн нутаг дэвсгэрт бүх нийтийн цэвэрлэгээний ажлыг зохион байгуулах хуваарь батлах тухай” А/01 дүгээр тушаалын дагуу зохион байгуулсан “Их цэвэрлэгээний 90 минут” арга хэмжээний хүрээнд манай байгууллага Бөхийн өргөөний уулзвараас зүүн тийш зүүн 4-н замын уулзвар хүртэл замын урд талын явган замын хог хаягдал болон халтиргаа гулгаа үүссэн цас мөсийг бүрэн цэвэрлэх ажилд идэвхтэй хамрагдсан.



# Цэвэрлэгээ







**Анхаарал хандуулсан баярлалаа**